

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУРШЛАГА

THE EXPERIENCES OF SOME FOREIGN COUNTRIES IN CONDUCTING OPERATIONS FOR ENSURING PUBLIC SAFETY



Д.БУЛГАН

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн магистр, цагдаагийн хошууч

BULGAN D.

(Police Major) Lecturer at the Department of Police Legislation of the Police School, Law Enforcement University

Товч агуулга: Гадаадын зарим улсын үндэсний аюулгүй байдал, түүний дотор олон нийтийн аюулгүй байдалд зохих анхаарал хандуулахыг хичээж судлаачийн хувьд хөрш орон ОХУ-ын, хүний эрх, эрх зүй, ардчилал, хамтын ажиллагаа өндөр хөгжсөн орны хувьд АНУ болон Япон зэрэг улсын цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж, өөрийн орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг эрэлхийлж, харьцуулан судалгаа хийлээ.

Abstract: In this article, as a researcher, I have tried to focus on security especially public safety of some foreign countries including neighboring country Russia, United States of America and Japan which are with well-developed human rights and law, democracy and cooperation as well as I've studied police operations for ensuring public safety, their legal regulations and experience and I've conducted a comparative study based on exploration of their legal framework and practices to seek possibilities to actualize in our police organizations.

Түлхүүр үгс: олон нийтийн аюулгүй байдал, цагдаагийн байгууллага, гадаад орны туршлага, сайн туршлага

Key words: public safety, police, comparative study, good practice

Удиртгал

Иргэд, олон нийтийн аюулгүй, амар тайван амьдралын баталгааг хангахын тулд цагдаагийн байгууллага үйл ажиллагааг улам хөгжүүлэх нь зайлшгүй юм. Тиймээс ч гадаадын улс орнуудын сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх нь цагдаагийн

байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга замыг бий болгоход чухал ач холбогдолтой.

Улс орон бүр янз бүрийн орчин нөхцөлтэйгээс гадна түүхэн хөгжил, нийгэм, эдийн засаг, соёлын хувьд ялгаатай учраас өөр өөрийн онцлогт тохирсон олон нийтийн аюулгүй байдлыг хангах менежментийн тогтолцоог бүрдүүлэх нь ойлгомжтой юм.

Монгол Улсад олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, ирээдүйн хөгжлийн асуудлыг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлоход орчин үеийн үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлага болон дэлхийн улс орны олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны туршлагыг харьцуулан судлах шаардлагатай юм.

Хүйтэн дайны төгсгөлөөс хойш аюулгүй байдлын тухай ойлголт дэлхий дахинд хувьсан өөрчлөгдөж, даяарчлал, хүний аюулгүй байдал, аюулгүйжүүлэх гэсэн үзэл баримтлалын хүрээнд судлагдаж байна. Даяарчлал нь аюулгүй байдлын салбарыг оролцуулан, улс хоорондын харилцан хамаарлыг нэмэгдүүлж байна.

Учир иймд гадаадын зарим улсын аюулгүй байдал, түүний дотор олон нийтийн аюулгүй байдалд зохих анхаарал хандуулахыг хичээж судлаачийн хувьд хөрш орон ОХУ-ын, хүний эрх, эрх зүй, ардчилал, хамтын ажиллагаа өндөр хөгжсөн орны хувьд АНУ болон Япон зэрэг улсын цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж, өөрийн орны цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг эрэлхийлж, харьцуулан судалгаа хийхийг зорилоо.

УИХ-ын тамгын газрын судалгаа,



МОНГОЛЫН
ПОЛИЦИЯ
АКАДЕМИ

шинжилгээний хэлтсээс 2013 онд “Олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмын талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт” сэдвийн хүрээнд судалгаа хийжээ. Мөн судлаач Б.Баянмөнх “Олон нийтийн аюулгүй байдлын талаарх гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалт” сэдэвт өгүүлэл бичжээ.

“Цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг олон нийтэд үйлчилгээ, тусламж үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хүн бүрийн үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх, амар тайван байдал болон хэв журам, хуулийг сахиулах явдал юм² гэж судлаачид тайлбарладаг.

Европын зөвлөлөөс “Цагдаагийн ёс зүйн Европын хууль³”-д цагдаагийн байгууллагын үндсэн зорилгын талаар дараахь зүйлийг тодорхойлжээ.

- Олон нийтийн амар тайван байдал, нийгэмд хууль, дэг журам сахиулах;
- Хүний эрхийн тухай Европын Конвенцид заасан хувь хүний суурь эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх;
- Гэмт хэрэг илрүүлэх;
- Олон нийтэд тусламж, үйлчилгээг үзүүлэх талаар заасан.

Дээрх олон улсын загвар хуулиудаар цагдаагийн байгууллагын үндсэн зорилтыг заасан бөгөөд олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг зохицуулсан нь харагдана. Нийгэм дэх амар тайван байдал, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалснаар олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндэс суурь бүрдэнэ.

Дэлхийн ихэнх улс орнуудад олон нийтийн аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын бүтцийг бий болгосон нь харагдана. Тухайлбал Австралид “Олон нийтийн аюулгүй байдлын Австралийн хүрээлэн”, Бразилд “Олон нийтийн аюулгүй байдлын үндэсний хэрэг эрхэлэх газар”, Канадад “Олон нийтийн аюулгүй байдал Канадын алба, Францид “Олон нийтийн аюулгүй байдлын комисс”, Японд “Үндэсний олон нийтийн аюулгүй байдлын комисс”, БНСУ-д Үндэсний цагдаагийн Комисс (Өмнөд Солонгос) Англид “Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, олон нийтийн

аюулгүй байдлын хэлтэс”, АНУ-д “Олон нийтийн аюулгүй байдлын хэлтэс”⁴ гэх мэт байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах тухай ойлголт нь олон улсад холбоо, мэдээллийн систем, иргэний хамгаалалт, онцгой байдлын менежмент, хүнсний аюулгүй байдал, байгалийн гамшиг, орон байрны аюулгүй байдал, эрүүл мэнд, хувийн хамгаалалтын байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдал, сүлжээ, инженерийн байгууламжийн аюулгүй байдал гэх мэт асуудлыг үүнд багтааж үздэг. Тиймээс судлаачийн хувьд зөвхөн цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг авч үзлээ.

АНУ-ын цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа.

АНУ-д Засгийн газар хууль сахиулах үйл ажиллагааг гол төлөв цагдаагийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Цагдаагийн байгууллага нь хууль сахиулах зорилгоор гэмт хэрэг мөрдөн шалгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий үүрэгтэй байгууллага юм.

АНУ-ын цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдалд тулгарах аюул болон бусад яаралтай тусламжийн үед анхны тусламжийг үзүүлж, олон нийтийн зарим барилга байгууламж, дэд бүтцийг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах төрийн албан тушаалтныг хамгаалах, зарим засан хүмүүжүүлэх газруудад үүрэг гүйцэтгэдэг байна.

Америкийн цагдаа (The Police in America)⁵ номонд цагдаагийн эргүүл нь гурван чиг үүрэг гүйцэтгэдэг талаар өгүүлжээ. Үүнд:

1. Гэмт хэргийг таслан зогсоох
2. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах
3. Үйлчилгээ үзүүлэх

Ийнхүү эргүүлийн 2 дахь үүрэг нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах бөгөөд иргэд олон нийтийг гэмт хэрэг болон бусад аюул заналаас хамгаалдаг.

Мөн энэхүү номонд цагдаагийн ажилд “peacekeeping and order maintenance” буюу “амгалан тайван байдлыг хангах ба хэв журам тогтоосон шийдвэрийн хэрэгжилтийг хангах” үйл ажиллагааны талаар тухайлан судалж авч үзсэн нь анхаарал татаж байна. Учир нь энэхүү үйл ажиллагааны хүрээнд замын хөдөлгөөний хяналт, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, дотоодын маргаан, зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл болон бусад хууль заасан үүрэг гүйцэтгэхээр

¹ Б.Баянмөнх. Олон нийтийн аюулгүй байдлын талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт. Цагдаа судлал. УБ., 2014. №2

² Monica den Boer, Changwon Pyo. “Good Policing: Instruments, Models and Practices” ISBN : 978-981-08-8126-9, Copyright@ 2011, p 17.

³ European Code of Police Ethics. <http://polis.osce.org/library/f/2687/500/CoE-FRA-RPT-2687-EN-500>



заажээ. Тухайлбал биеэ үнэлэх, мөрийтэй тоглоом тоглох, хар тамхичид, сэтгэл мэдрэлийн өвчтөн, насанд хүрээгүй зөрчил гаргагчидтай холбоотой хэв журам сахиулах ажиллагааг багтаан тайлбарлажээ.

Энэхүү ажиллагаа нь НҮБ-ийн энхийг сахиулах үйл ажиллагааны тухай өгүүлээгүй бөгөөд цагдаагийн байгууллагаас хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай, энх тайван байдлыг сахиулах ажиллагаа ба түүнтэй холбоотойгоор хэв журам сахиулах үйл ажиллагааг авч үзсэн нь харагдана.

АНУ-ын цагдаагийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагааны нэг олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны онцлогийг тоймлон дурдвал:

Нэг. АНУ-д аюулгүй байдлыг хангахад хууль сахиулах болон бусад байгууллагын хамтын ажиллагааг хэрэгждэг байна. Тухайлбал Эх орны Аюулгүй байдлын газар, Аюулгүй байдлын зөвлөл, АНУ-ын Нууц Алба (Secret Service), Холбооны мөрдөх товчоо, Холбооны онцгой байдлын удирдлага, зохион байгуулалтын агентлаг (FEMA) болон 18000 гаруй хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаагаар аюулгүй байдлыг хангаж ажилладаг⁴ байна. Жишээлбэл: Эх орны Аюулгүй байдлын газрын Нарийн бичгийн дарга нь Аюулгүй байдлын зөвлөлтэй зөвшилцсөний эцэст Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай арга хэмжээнүүдийг тодорхойлдог. Харин АНУ-ын Нууц Алба бол Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай арга хэмжээнүүдийг хамгаалах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, боловсруулах тэргүүлэх агентлаг юм. Холбооны Мөрдөх Товчоо нь хямралын үеийн менежмент, терроризмын эсрэг ажиллагаа, барьцаалагдсан хүмүүсийг аврах, тагнуулын чиглэлээр тэргүүлэх үүрэг бүхий агентлаг, харин Холбооны Онцгой байдлын удирдлага, зохион байгуулалтын агентлаг (FEMA) гамшгийг бууруулах ажиллагаа, аврах ажиллагаа буюу хор уршгийн менежмент хариуцсан тэргүүлэх агентлаг юм.

Хоёр. АНУ-ын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны гол инноваци нь "олон нийтийн цагдаа" (community policing), "хагархай цонхны үйл ажиллагаа" (broken windows theory), "асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа" (problem-oriented policing), "нотолгоонд суурилсан ажиллагаа" (evidence-based policing), "компьютер статистик" (Compstat) гэх мэт хууль сахиулах үйл ажиллагааны стратегийг нэвтрүүлсэн нь үйл ажиллагааны өөрчлөлт,

шинэчлэлийн үндэс суурь болсон⁴. Эдгээр үйл ажиллагааны инноваци нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ч мөн хэрэглэгддэг юм.

Гурав. АНУ-д цагдаа, хууль сахиулах байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ аюул, занал, эрсдэлийн судалгаа, үнэлгээг өндөр түвшинд хийдэг байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангахдаа нийтлэг гардаг гэмт хэрэг, эвдэн сүйтгэх гэмт хэрэг, эсэргүүцэн жагсагчид, гал түймэр, эрчим хүч тасрах, байгалийн болон бусад гамшиг зэрэг байж болох, илэрхий заналхийллээс эхлэн эрсдэлийн үнэлгээ хийдэг. Тухайлбал нийтийг хамарсан арга хэмжээний үед хууль сахиулагчид маш хүчтэй цасан шуурга болно гэж бэлтгэх, үзэсгэлэн, яармагийн үед Торнадо хар шуурга гарч болзошгүй талаар бэлтгэл ажил хангах шаардлагатай болдог. Ноцтой мэдээ, мэдээлэл ирвэл түүнд зориулсан төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Дараа нь боломжит заналхийлэлтэй тэмцэх аюулгүй байдлын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Нөхцөл байдал хүндэрсэн олон хэлбэрээр төсөөлөл боловсруулж, төсөөлөл бүрийн чиглэлээр аюулыг бууруулахаар төлөвлөдөг.

Эх орны Аюулгүй байдлыг хангах газрын Эрсдлийн менежментын дивиз "Сул талыг олж тогтоох бие даасан үнэлгээний аргачлал"⁴ нэртэй онлайн хөтөлбөрийг боловсруулсан. Үүнийг стадион, тайз, хурлын төв, урлагийн төв, хурдны замын менежерүүдэд зориулан хийсэн аж. Тээврийн удирдлагын газрын хэрэглэдэг бие даан үнэлэх аргачлалыг загварчилж, онлайн хэлбэрээр ашиглах болсон нь олон нийтийн барилга байгууламжийн менежерийн аюулгүй байдалд анхаарах түвшинг ихэсгэж өгдөг. Энэ аргачлал нь тодорхой барилга байгууламжийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх боломжийг менежерт олгоно. Барилга байгууламж бүрийн аюулгүй байдлын наад захын түвшинг бий болгоход туслах, эрсдэлтэй дэд бүтцэд хамгийн сайн туршлагыг нэвтрүүлэхэд ViSAT модулиуд туслах юм.

Дөрөв. АНУ-ын олон нийтийн аюулгүй байдлыг хангахад хувийн секторыг оролцуулдаг. Тухайлбал үндэсний хэмжээний томоохон спортын тэмцээн, наадам, концерт, олон нийтийн зугаа цэнгээний олон арга хэмжээ зохиогддог барилга байгууламж,

⁴ Public safety organization. https://en.wikipedia.org/wiki/Public_safety_organizations



МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УНДЭСНИЙ
КОМИСС

компаниудыг хувийн секторууд эзэмшдэг. Арга хэмжээний аюулгүй байдлыг хангахын тулд хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах хувийн хамгаалалтын компанийг барилга байгууламжийн эзэмшигчид хөлсөлнө. Хувийн хамгаалалтын компаниуд нь хууль сахиулах байгууллагын үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх эсвэл арга хэмжээний хамгаалалтыг хийхэд тэргүүлэх үүрэгтэй оролцдог. Зарим тохиолдолд хууль сахиулах байгууллага хамгаалалтын арга хэмжээнд огт оролцохгүй байх үе ч бас бий.

Тав. Сайн дурынханы үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой. Цагдаагийн удирдлагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийг хамгаалахын тулд бусад нөөц бололцоог хайж эхэлсэн. Ингээд иргэд, олон нийтийн түншлэлийг бий болгосон. АНУ-д олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэмэгдэл хүчинд сайн дурынхан орно. Сайн дурынхан хамгаалалтанд ажиллахад зардал бага, нөөц бололцоо хэмнэхээс гадна цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг олон түмэнд харуулдаг учраас ач холбогдол ихтэй⁵.

Зургаа. Мэдээлэл (тагнуулын болон бусад) цуглуулах ажиллагаа олон нийтийн аюулгүй байдлыг хангах чухал хэрэгсэл юм. Ямар ч эх сурвалжаас хамгийн сайн тагнуулын мэдээ авагдаж болно. (хууль сахиулах байгууллагууд, олон нийт, бизнесийн хүрээнийхэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээ, эрүүгийн гэмт хэрэгтнүүд, болон бусад) Хууль бус ажиллагаа хийхээр төлөвлөж байгаа террорист бүлгүүд болон орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн хооронд холбоо байж болохыг дэлхийн ямар ч цагдаагийн байгууллага хүлээн зөвшөөрнө. Хууль бусаар тамхи хил давуулах ажиллагаа нь террорист бүлгийг санхүүжүүлэхтэй холбоотой байж болно гэх мэт мэдээллийг цуглуулах ажиллагаа чухал ач холбогдолтой.

“Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа террорист үйл ажиллагаанаас сэргийлэх, тагнуулын мэдээ, мэдээллийг ихэсгэхэд үнэлж баршгүй нөлөө үзүүлдэг” гэж үздэг. Жишээлбэл удахгүй зохиогдох нийтийг хамарсан арга хэмжээний талаарх мэдээллийг шууд хүлээн авч байхын тулд тэргүүлэх агентлаг нь тагнуулын эх сурвалжтай олон сарын өмнө уулзаж, холбоо тогтоосон байх шаардлагатай.

Үндэсний хэмжээний том арга хэмжээний

үед Холбооны мөрдөх товчоо тагнуулын мэдээллээр хангах тэргүүлэх агентлаг болдог. Тусгай арга хэмжээтэй холбоотой бүхий л арга хэмжээний талаар Холбооны мөрдөх товчооноос “Ажиллагааны концепц” нэртэй бичиг баримтыг боловсруулсан бөгөөд шаардлага үндэслэлийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах зэрэг ажлын бүх эргэх мөчлөгийг тусгасан юм.

Япон улсын цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа.

Япон улсад цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны гол эрх зүйн зохицуулалт нь Цагдаагийн байгууллагын тухай хууль (1954), Цагдаагийн үүрэг гүйцэтгэх тухай хууль (1948), Цагдаагийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааны журам (1969) гэх мэт хууль, хууль тогтоомжийг дурдаж болно. Цагдаагийн байгууллагын тухай хууль нь цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, түүнчлэн үндэсний болон мужийн түвшинд нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Харин Цагдаагийн үүрэг гүйцэтгэх тухай хууль нь цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон хууль⁶ юм.

Япон улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн нэгдүгээр зүйлд⁷ “цагдаагийн байгууллага нь хүний эрх болон эрх чөлөөг хүндэтгэн, олон нийтийн аюулгүй байдал, хэв журмыг сахиулах үйл ажиллагаандаа ардчилсан зарчмыг үндсэн чиглэлээ болгож, хяналт ба удирдлагыг хангаж, албан үүргээ бүтээмжтэйгээр гүйцэлдүүлэх, цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахыг зорилгоо болгоно” гэжээ.

Японы засгийн газар 1874 онд иргэний цагдаагийн тогтолцоотойгоор Европын-загвараар дотоодын хямралт нөхцөл байдал, аюулгүй байдлыг хангах болон хэв журам сахиулахаар байгуулагдсан.

Японы цагдаагийн байгууллага нь Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний комисс, Үндэсний цагдаагийн газар, Цагдаагийн захиргаа, удирдлага товчоо, эрүүгийн хэрэг мөрдөх товчоо, замын цагдаагийн товчоо, хамгаалалтын товчоо, Бүсийн Олон нийтийн аюулгүй байдлын товчоо, Цагдаагийн

⁶ Edward C. Planning And Managing Security For Major Special Events: Guidelines for Law Enforcement. p 7.

⁷ Anthony A. Braga, David L. Weisburd. Police Innovation and Crime Prevention: Lessons Learned from Police Research over the Past 20 Years. <https://www.ncjrs.gov/pdffiles1/nij/grants/218585.pdf>

⁵ Самуэл Волкер, Чарлз Катз. Америкийн цагдаагийн тухай. 5 дахь хэвлэл. 195 дахь тал. Samuel Walker, Charles M.Katz. The Police in America an introduction. 5th edition. p 195.

харилцаа холбооны хэлтэс, Эзэн хааны хамгаалалт, орон нутгийн цагдаагийн байгууллагуудаас бүрддэг.

Японы Цагдаагийн байгууллагын үүрэг хариуцлага нь “хүний амь нас, амь бие буюу эд хөрөнгийг хамгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хайж олох, сэжигтэнг баривчлах, замын хөдөлгөөний зохицуулалт болон бусад олон нийтийн аюулгүй байдал, хэв журмыг сахиулахад” оршино.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын тогтолцоонд цагдаагийн байгууллага нь чухал үүрэгтэй оролцдог⁸.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын тогтолцоонд цагдаагийн байгууллага нь чухал үүрэгтэй оролцдог⁹.

1. Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний комисс (National Public Safety Commission) нь үндэсний цагдаагийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй бол мужийн олон нийтийн аюулгүй байдлын комисс нь мужийн цагдаагийн үйл ажиллагааг зохицуулдаг. Улсын ерөнхий сайдаас Үндэсний Олон Нийтийн Аюулгүй Байдлын Комиссын даргыг томилох бөгөөд тухайн томилгоонд үндсэн хоёр шаардлага тавигддаг. Үүнд: улс төрийн төвийг сахих байдал болон нийтийн аюулгүй байдалтай холбогдох хариуцлага.

2. Үндэсний цагдаагийн байгууллага. Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний комисс болон үндэсний цагдаагийн газрын ерөнхий комиссарын хяналт дор цагдаагийн байгууллага үүрэг гүйцэтгэдэг. Үндэсний цагдаагийн байгууллага нь ужийн цагдаагийн байгууллагын үүргээ гүйцэтгэх, аюулгүй байдалтай холбоотой ажиллагаануудыг давхар хариуцан ажилладаг. Цагдаагийн байгууллагын үүргээ гүйцэтгэх ажиллагааны нэн чухал зүйлс бол цагдаагийн боловсрол, сургалт, харилцаа холбоо болон гэмт хэрэг мөрдөлт юм.

3. Мужийн цагдаагийн байгууллага. Япон улсын 47 мужийн цагдаагийн хэлтэст 1,201 цагдаагийн байгууллага болон мужийн цагдаагийн сургуулиуд байдаг.

Япон улсад цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг нь иргэд, олон нийтийн

аюулгүй байдлыг хангахад чухал анхаарал хандуулан ажилладаг бөгөөд энэ талаар Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний зөвлөл (National Public Safety Commission) ажилладаг. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн дөрөвдүгээр зүйлд “Ерөнхий сайдын харьяалал доор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг байгуулах” талаар заасан.

Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний зөвлөл нь цагдаагийн байгууллагын үйл ажилгааг удирдан явуулж, цагдаагийн алба хаагчдын сургалт, цагдаагийн холбоо, мэдээллийн арга технологид тулгуурлан мэдээллийг нарийвчлан задлан шинжлэх, гэмт хэргийн статистик, гэмт хэргийн криминалистик шинжилгээнд дүгнэлт хийх, цагдаагийн тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажилгааг нэгдсэн харьяалал доор байлгахын сацуу цагдаагийн байгууллагын захиргааг зохицуулснаар хүний эрх болон эрх чөлөөг хамгаалан, олон нийтийн амгалан тайван байдлыг болон хэв журмыг сахиулах үүрэгтэй ажилдаг.

Үндэсний олон нийтийн байдлын зөвлөл нь хуульд заасан заалтыг биелүүлэхийн тулд дараахь ажил үүргээр Үндэсний Цагдаагийн газарт хяналт тавьж ажилдаг.

1. Цагдаагийн байгууллагын тогтолцооны талаар хууль санаачлах буюу төлөвлөгөө боловсруулах;
2. Цагдаагийн байгууллагад холбогдох улсын төсөвд хяналт тавих;
3. Цагдаагийн байгууллагатай холбогдох төрийн бодлогод үнэлэлт хийх;
4. Цагдаагийн байгууллагын дараахь үйл ажиллагааны зохицуулалтыг хийдэг.
 - ард олонд аюул нүүрлэж болзошгүй том хэмжээний гай гамшигтай холбоотой зохицуулалт хийх;
 - орон нутгийн амгалан тайван байдлыг алдагдуулах аюултай үймээн самуунтай холбогдох зохицуулалт;
 - олон Улсын харилцаанд аюул үзүүлэх, бусад улс орнуудын эрх ашгийг ноцтойгоор хохироож болзошгүй агаарын нисдэг тэргийг хүчээр буулгах, хүнийг барьцаанд авах, тэсэрч дэлбэрэх зүйлийг авч явах буюу үүнтэй дүйцэх бусад гэмт хэрэгтэй холбогдох асуудлуудыг зохицуулах гэх мэт.

5. Онц байдалд авах арга хэмжээний төлөвлөлт буюу хэрэгжүүлэлттэй холбоотой зохицуулалт хийх

6. Үндэсний хэмжээний зохион байгуулалтай гэмт хэрэг болон бусад төрлийн гэмт хэрэгтэй холбоотой асуудал;

- Хүний амь нас, амь бие, өмч

⁸ Department of Homeland Security-Vulnerability Identification Self-Assessment Tool-Transportation (DHS-VISAT-T). https://www.reginfo.gov/public/do/PRAViewIC?ref_nbr=200902-1652-002&icID=20969

⁹ James K. Stew. Public Safety and Private Police. Public Administration Review, Vol. 45, Special Issue: Law and Public Affairs (Nov.,1985), pp. 758-765. <https://www.jstor.org/stable/pdf/3135033.pdf>.



хөрөнгөнд хохирол учирсан болон учруулж болзошгүй асуудлууд

7. Улс орны хурдны замын болон зам тээврийн хяналттай холбоотой асуудлууд;

8. Гэмт хэргийн талаарх мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх;

9. Олон улсын цагдаагийн байгууллага болон бусад улс орны цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах гэх мэт 25 үүргийг тусгажээ.

Үндэсний цагдаагийн газрын дарга нь Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн удирдлагад захирагдаж, Цагдаагийн газрын албыг нэгтгэн хариуцаж, ажилтнуудыг томилж, халах болон ажилтнуудын албан үүргийн гүйцэтгэлийг нэгтгэн хянахын сацуу Цагдаагийн газарт харьяалагдах албан үүргийн тухайд засаг захиргааны нэгжийн цагдаагийн байгууллагыг удирдан ажилладаг. Үндэсний цагдаагийн газар нь хуульд заасан ажил үүргийг гүйцэтгэх буюу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тусалж дэмжинэ.

Үндэсний цагдаагийн газарт Тамгын газраас гадна дараахь 5 товчоо байна.

➤ Олон нийтийн аюулгүй байдлын товчоо (Community Safety Bureau)

➤ Эрүүгийн мөрдөн байцаах товчоо (Criminal Investigation Bureau)

➤ Зам тээврийн товчоо (Traffic Bureau)

➤ Хамгаалалтын товчоо (Security Bureau)

➤ Мэдээлэл холбооны товчоо (Information and Communications Bureau)

Эдгээр таван товчоогоос олон нийтийн аюулгүй байдлын болон хамгаалалтын үйл ажиллагаа хэрэгжүүлдэг хэлтсийн үйл ажиллагааг онцлон авч үзье.

Олон нийтийн аюулгүйн байдлын товчоо нь Япон улсын "Цагдаагийн байгууллагын тухай хууль"-ийн 22 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн аюулгүйн байдлын хэлтэст, Цагдаагийн ерөнхий газарт харьяалагдах ажил үүргийг хийж гүйцэтгэдэг байна.

1. Гэмт хэрэг, осол аваар болон түүнээс бусад асуудлуудтай холбоотой ард иргэдийн аюулгүй байдал болон амар амгалан тайван байдлыг хангах;

2. Олон нийтэд түшиглэсэн цагдаа, эргүүл хийх бусад үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх;

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;

4. Аюулгүй байдлыг хангахтай холбоотой бусад асуудлууд гэх мэт.

Хамгаалалтын товчоо нь Цагдаагийн ерөнхий газрын ажил үүргийн дагуу дараахь

үүргийг гүйцэтгэнэ.

1 Хамгаалалтын алба;

2 Эзэн хааны харуул;

3 Чухал хүмүүсийн хамгаалалт;

4 Хамгаалалтын хэрэгжүүлэлт;

5 Онцгой байдал давах арга хэмжээний төлөвлөгөө буюу хэрэгжүүлэлтийн зарим асуудал гэх мэт үүргүүдийг гүйцэтгэдэг.

Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хувьд: Япон улсын цагдаагийн засаг захиргааны нэгжүүдэд тухайн нэгжийн цагдаагийн алба ажилладаг байна.

Засаг захиргааны нэгжийн захирагчийн харьяалалд тухайн нэгжийн олон нийтийн аюулгүй байдлын зөвлөл байна. Засаг захиргааны нэгжийн цагдаагийн алба нь тус тусын засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэр дээр байрлан, хуульд заасан үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Засаг захиргааны нэгжийн Олон нийтийн аюулгүй байдлын зөвлөл нь засаг захиргааны нэгжийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хуульд зааснаар хотын харьяа мужид зөвлөлийн таван гишүүн, заагдсан мужаас бусад мужуудад зөвлөлийн гурван гишүүнтэйгээр байгуулагдана.

Засаг захиргааны нэгжийн олон нийтийн аюулгүй байдлын зөвлөл нь тухайн нэгжийн цагдаагийн албыг удирдаж ажиллана. Засаг захиргааны нэгжийн олон нийтийн аюулгүй байдлын зөвлөл нь Үндэсний олон нийтийн аюулгүй байдлын зөвлөл болон Засаг захиргааны нэгжийн олон нийтийн аюулгүй байдлын бусад зөвлөлтөй ямагт холбоотой ажилдаг.

Цагдаагийн ерөнхий газар болон Засаг захиргааны нэгжийн цагдаагийн байгууллага нь тус тус Олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн удирдлага доор байж, хотын цагдаагийн алба болон Засаг захиргааны нэгжийн цагдаагийн албаны ажил үүргийг гүйцэтгэх бөгөөд зохион байгуулалтын бүтэцэд дээрх таван хэлтэс багтана.

Бүс нутгийн дэвсгэрийг таван дүүрэгт хувааж, бүс нутгийн дэвсгэр болгонд цагдаагийн хэсэг байна.

Япон улсын Олон нийтийн аюулгүй байдлын товчоо нь аюулгүй байдлын бодлого боловсруулж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилладаг. Мөн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тоног төхөөрөмж, тактикийн судалгаа явуулж, бодлогыг зохицуулж хяналт тавьдаг байна. Аюулгүй байдлын товчоо Улсын хилээр орох, гарах хяналтын тухай хууль, Гадаадын иргэний бүртгэлийн тухай хууль зөрчсөн хэргийг мөрдөн шалгах



замаар гадаадын иргэд болон улс төрийн радикал бүлэгт аюулгүй байдлын тагнуулын үйл ажиллагаа явуулдаг. Мөн онцгой байдал, байгалийн гамшгийн үед аюулгүй байдлын бодлого хэрэгжүүлдэг.

Ийнхүү япон улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онцлог нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах явдал бөгөөд олон нийтийн аюулгүй байдлын Үндэсний зөвлөлтэй хамтран байнгын үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байдаг.

Японы цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны гол онцлог нь цагдаагийн кобон юм. Энэ нь худалдаа үйлчилгээний талбай, орон сууцны хороолол, автобус, метроны буудлуудад ойр байрладаг бөгөөд иргэдэд хамгийн анхны цагдаагийн тусламж үйлчилгээг үзүүлдэг нэгж юм. Японд нийт 14,100 цагдаагийн кобон байдаг бөгөөд үүнээс 7600 нь орон сууцны хороололд байрладаг. Орон сууцны хороололд байрладаг цагдаагийн кобон голдуу ганц цагдаа ажилладаг бол, бусад кобон нь 3-5 цагдаа ажилладаг. Японы нийт цагдаагийн албан хаагчдын 20 орчим хувь нь цагдаагийн кобонд ажилладаг. Тэдний өдөр тутмын ажлуудад иргэдээс гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээн авах, олсон гэсэн эд зүйлийг зохицуулах, төөрсөн будилсан иргэдэд зам заах, хариуцдаг дүүрэгтээ явган, дугуйгаар, машинаар эргүүл хийн, сэжиг бүхий этгээдийг шалгах, гэмтсэн бэртсэн хүмүүст туслах гэх мэт үүргүүдийг гүйцэтгэдэг. Эргүүл хийх явцад яаралтай үед, цагдаагийн бүхээг бүрт хуваарилагдсан байдаг радио холбоо бүхий машинаар цагдаагийн төвтэйгөө холбогддог. Тэдний бас нэгэн гол үүрэг нь жилд 2 удаа тухайн дүүрэгт оршин суудаг айлуудын өрхийн тэргүүнээр анкет бөглүүлж авах ажил байдаг. Энэ анкетад оршин суугчдын нэр, нас, албан тушаал, ажлын газрын хаяг, автомашины дугаар, өөр газарт амьдардаг хамаатан садных нь мэдээлэл ордог. Гэмт хэрэг гарсан үед эсвэл мөрдөн байцаалт явагдах үед эдгээр мэдээллийг ашигладаг.

Японы цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны гол онцлог нь цагдаагийн кобон юм. Энэ нь худалдаа үйлчилгээний талбай, орон сууцны хороолол, автобус, метроны буудлуудад ойр байрладаг бөгөөд иргэдэд хамгийн анхны цагдаагийн тусламж үйлчилгээг үзүүлдэг нэгж юм. Японд нийт 14,100 цагдаагийн кобон байдаг бөгөөд үүнээс 7600 нь орон сууцны хороололд байрладаг. Орон сууцны хороололд байрладаг цагдаагийн кобон голдуу ганц

цагдаа ажилладаг бол, бусад кобон нь 3-5 цагдаа ажилладаг. Японы нийт цагдаагийн албан хаагчдын 20 орчим хувь нь цагдаагийн кобонд ажилладаг. Тэдний өдөр тутмын ажлуудад иргэдээс гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээн авах, олсон гэсэн эд зүйлийг зохицуулах, төөрсөн будилсан иргэдэд зам заах, хариуцдаг дүүрэгтээ явган, дугуйгаар, машинаар эргүүл хийн, сэжиг бүхий этгээдийг шалгах, гэмтсэн бэртсэн хүмүүст туслах гэх мэт үүргүүдийг гүйцэтгэдэг. Эргүүл хийх явцад яаралтай үед, цагдаагийн бүхээг бүрт хуваарилагдсан байдаг радио холбоо бүхий машинаар цагдаагийн төвтэйгөө холбогддог. Тэдний бас нэгэн гол үүрэг нь жилд 2 удаа тухайн дүүрэгт оршин суудаг айлуудын өрхийн тэргүүнээр анкет бөглүүлж авах ажил байдаг. Энэ анкетад оршин суугчдын нэр, нас, албан тушаал, ажлын газрын хаяг, автомашины дугаар, өөр газарт амьдардаг хамаатан садных нь мэдээлэл ордог. Гэмт хэрэг гарсан үед эсвэл мөрдөн байцаалт явагдах үед эдгээр мэдээллийг ашигладаг.

Манай хойд хөрш ОХУ-ын тухайд. 2011 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ОХУ-ын "Цагдаагийн тухай" холбооны хууль¹⁰ батлагдсан бөгөөд уг хуулийн 4 дүгээр зүйлд "цагдаагийн байгууллага нь Дотоод хэргийн яамны нэгдсэн төв системийн бүрэлдэхүүн хэсэг" гэж тодорхойлсон.

ОХУ-ын Дотоод хэргийн яам, цагдаагийн байгууллага, харьяа нутаг дэвсгэрийн байгууллагууд болон хэлтсүүдийн дарга нар өөрсдийн эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагааг удирдаж, хэрэгжүүлж, цагдаагийн үүрэг хариуцлагын биелэлтийг хариуцан ажилладаг. Цагдаагийн байгууллага нь ОХУ-ын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй хүний эрх, эрх чөлөө, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, өмч болон нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхээр төв байгууллагын харьяа хэлтэс, байгууллага, алба ажиллана. Цагдаагийн бүрэлдэхүүн, цагдаагийн хэлтсүүдийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах журмыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар албажуулсан байдаг.

Цагдаагийн тухай холбооны хуулийн 2 дугаар зүйлд цагдаагийн үйл ажиллагааны

¹⁰ [Федеральный закон от 07.02.2011 N 3-ФЗ \(ред. от 03.07.2016\) "О полиции" \(с изм. и доп., вступ. в силу с 04.07.2016\). \[www.consultant.ru\]\(http://www.consultant.ru\)](#)

үндсэн чиглэлүүдийг заасан.

1. Хувь хүн, нийгэм, төрийн эрхийг хууль бус үйлдлээс хамгаалах;

2. Гэмт хэрэг болон захиргааны хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;

3. Гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулах;

4. Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах;

5. Захиргааны зөрчлийн хэрэг үүсгэн шалгах, захиргааны шийтгэлийг ногдуулах;

6. Олон нийтийн газар хэв журам сахиулах;

7. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

8. Зэвсгийн эргэлтийн талаарх ОХУ-ын хууль тогтоомжийн мөрдөлтөнд хяналт тавих;

9. Хувийн мөрдлөгийн болон хамгаалалтын үйл ажиллагааны салбар дахь ОХУ-ын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

10. Өмч хөрөнгө, объектуудыг хамгаалах, тэр дундаа гэрээний үндсэн дээр хамгаалах;

11. Эрүүгийн хэргийн хохирогч, гэрч, бусад оролцогчид, шүүгч, прокурор, мөрдөн байцаагчид, хууль сахиулах болон хяналтын байгууллагуудын албан тушаалтнууд болон бусад хамгаалах шаардлагатай этгээдүүдийг улсын хамгаалалтад авах;

12. Шинжилгээ, криминалистикийн үйл ажиллагаа явуулах.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн шийдвэрээр цагдаагийн ажилтнууд нь олон улсын энх тайван болон аюулгүй байдлыг дэмжих, сэргээх үйл ажиллагаанд оролцож болно.

Цагдаагийн үйл ажиллагааны үндсэн хоёр чиглэл нь хувь хүн, нийгэм, төрийн эрхийг зөрчсөн үйлдлээс хамгаалах болон гэмт хэрэг, захиргааны хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагаа явуулах юм.

ОХУ-ын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хууль, эрх зүйн үндэс нь ОХУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ, холбооны Үндсэн хууль, Аюулгүй байдлын тухай холбооны хууль, бусад хууль, ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги, түүнчлэн холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас баталсан хэм хэмжээний акт, хууль эрх зүйн бусад акт, орон нутгийн байгууллагуудаас гаргасан эрх зүйн актаас бүрдэнэ.

Холбооны Засгийн газраас 2008 оны арваннэгдүгээр сарын 17-нд “ОХУ-ын 2020

он хүртэлх урт хугацааны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал”¹¹-ыг баталсан. Үүнд олон нийтийн хэв журам, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийг тодорхойлсон.

Мөн ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын стратеги¹² нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар 2015 онд шинэчлэн батласан бөгөөд урт хугацаанд төрийн бодлогын гол чиглэл, хүний аюулгүй байдлын баталгаа, ялангуяа хүүхэд, өсвөр насныханы аюулгүй байдлыг хангах талаарх хууль эрх зүйг сайжруулах, цэргийн гэмт хэрэг, авлига, хээл хахуул, хэт туйлшрагчаас урьдчилан сэргийлэх, хууль сахиулах олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр зохицуулсан нь төрийн үүргийг бэхжүүлсэн чухал ач холбогдолтой болжээ.

“ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын стратеги” нь 6 хэсэг, 116 зүйлээс бүрдсэн байна. Зургаан хэсгийг тоймловол:

1. Нийтлэг үндэслэл;

2. Орчин үеийн дэлхий ба ОХУ;

3. ОХУ-ын үндэсний ашиг сонирхол ба үндэсний стратегийн тэргүүлэх чиглэл;

4. Үндэсний аюулгүй байдал; Үүнд 1) Үндэсний батлан хамгаалах; 2) Төр, нийгмийн аюулгүй байдал; 3) Оросын иргэний амьдралын дээшлэлт; 4) Эдийн засгийн өсөлт; 5) Шинжлэх ухаан, технологи ба боловсрол; 6) Эрүүл мэнд (эрүүлийг хамгаалах); 7) Соёл; 8) Экологи ба үндэсний байгалийн ашиглалт гэх зэрэг;

5. Энэхүү стратегийн зохион байгуулалтын эрх зүйн хэм хэмжээний болон мэдээллийн үндэс;

6. Үндэсний аюулгүй байдлын үзүүлэлт зэргийг багтаажээ.

Үүнээс гадна “ОХУ-ын олон нийтийн аюулгүй байдлын үзэл баримтлал”¹³ (Концепция общественной безопасности в Российской Федерации)-ыг баталсан бөгөөд энэ үзэл баримтлал нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг бөгөөд олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар үзэл бодлын тогтолцоог бүрдүүлсэн.

Энэ үзэл баримтлал нь ОХУ-ын олон нийтийн аюулгүй байдалд учрах аюул заналын гол эх сурвалжийг тодорхойлж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зорилго, зорилт, зарчим, төрийн эрх бүхий байгууллага, орон

¹¹ Концепция долгосрочного социально-экономического развития российской федерации на период до 2020 года. www.consultant.ru

¹² О Стратегии национальной безопасности Российской Федерации. Указ Президента Российской Федерации от 31 декабря 2015 года N 683.

¹³ Концепция общественной безопасности в Российской Федерации. kremlin.ru/acts/news/19653



МОНГОЛЫН
Дотоод
Хэрэг
Яамд



нутгийн засаг захиргаа, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад оролцож буй бусад байгууллага, иргэд, олон нийтийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон.

Олон нийтийн аюулгүй байдлын үзэл баримтлал нь ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги болон ОХУ-ын урт хугацааны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлалд заасны дагуу боловсруулагдсан байна.

Олон нийтийн аюулгүй байдлын үйл ажиллагааны үндсэн чиглэл

а) терроризмын эсрэг;
б) хэт даврах үйл ажиллагааны эсрэг тэмцэх;

в) гэмт хэрэг болон хууль бус бусад халдлагатай тэмцэх;

г) авилгатай тэмцэх;

д) байгалийн болон хүмүүний гаралтай онцгой байдлын үед хүн амыг хамгаалах салбарт- байгалийн болон хүний гараар хийгдэх гамшиг, галын аюул, онцгой нөхцөл байдлаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, иргэний хамгаалалтын чиглэлээр хяналт тавих, учруулсан хохирол, алдагдлын хэмжээг бууруулах;

е) хууль бус цагаачлалтай тэмцэх;

ж) хууль сахиулах олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх гэсэн чиглэлийг тодорхойлсон.

Судалгаанаас харахад ОХУ-ын хувьд аюулгүй байдлыг хангах салбарт үзэл баримтлал, төрийн хөтөлбөр, стратегийн зорилго нь - ОХУ-ын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны чанар, гэмт хэргийн үр нөлөөнөөс болон нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах, түүнчлэн хүн амын итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

С.Ю Чапчиков: Олон нийтийн аюулгүй байдлын үзэл баримтлал, стратегийн төлөвлөлтийн үндсэн баримт бичиг нь төрийн бодлогыг тодорхойлох нь сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлдээ[□] төрийн хөтөлбөрийн зорилгыг дараахь байдлаар тодорхойлжээ.

➤ Шүүхийн өмнөх мөрдөн байцаалтын чанар, үр ашгийг сайжруулах;

➤ Мөрдөн байцаах үйл ажиллагаа, хэрэг бүртгэх ажиллагааны үр ашгийг сайжруулах;

➤ Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн өмчийг хамгаалах ажлын үр нөлөөг сайжруулах;

➤ Замын хөдөлгөөний аюулгүй

байдлыг сайжруулах;

➤ ОХУ-ын Дотоодын цэргийн үйл ажиллагааны чадавх, үйлчилгээг сайжруулах;

➤ ОХУ-ын Дотоод хэргийн яамны системийн үйл ажиллагааны чадавх, чанарыг дээшлүүлэх явдал юм гэсэн байна.

Эдгээр хөтөлбөрүүд зорилго, зорилтодоо хүрэх тодорхой шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. Үүнд:

➤ Онц хүнд гэмт хэрэг, гэмт хэргийн тоо;

➤ Учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн хувь хэмжээ;

➤ Гэмт хэрэгтнүүдийн тоо;

➤ Олон нийтийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн цэцэрлэг, гудамжинд үйлдэгдсэн хүнд болон онц хүнд гэмт хэргийн тоо;

➤ Иргэдийн сэтгэл ханамжийн түвшин, хувийн болон эд хөрөнгийн ашиг сонирхолын аюулгүй байдал гэх мэт.

ОХУ-ын хувьд иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад илүү анхаарч цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нилээд шинэчлэл хийгдсэн нь харагдаж байна.

Эцэст нь дүгнэвэл: АНУ, Япон, ОХУ-ын цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь өөр хоорондоо ялгаатай боловч гол зорилго нь иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг бүхий л талаас хангасан, эрх зүй, зохион байгуулалт, арга зүйн хувьд өндөр түвшинд гүйцэтгэж буй нь ажиглагдана. Тухайлбал АНУ-ын цагдаагийн байгууллага нь хууль сахиулах үйл ажиллагаанд нэвтрүүлсэн стратеги нь энгийн хэрнээ үр дүнтэй. Цагдаагийн байгууллагын үйлчилгээний ач холбогдол нь олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг явуулж, иргэдэд үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээг анхан шатны нэгжээс шуурхай, хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлэх орон зайг бий болгох зорилгоор зохион байгуулагдсан байна. Мөн олон нийтийн аюулгүй байдлыг хангахад хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг чухалчилан ажиллаж байна.

ОХУ-ын хувьд олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шинэчлэл хийгдэж, үйл ажиллагаагаа улам сайжруулсан нь харагдана. Эндээс Монгол Улсын хувьд "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны стратеги, үзэл баримтлал, үндсэн чиглэл" боловсруулах

шаардлагатай гэсэн саналтай байна.

Япон улсын хувьд иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бүхэл тогтолцоо ажиллах бөгөөд бүхий л талаас цогцоор нь асуудлыг шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл Төрийн аюулгүй байдлыг сахин хамгаалах зөвлөл нь Япон улсын олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг удирдаж, цагдаагийн ажилтны сургалт, харилцаа холбоо, мэдээлэл технологийн дүн шинжилгээ, криминологи, гэмт хэргийн статистик болон цагдаагийн байгууллагын тоног төхөөрөмжинд хяналт тавьж, хэрэгжилтийг нь хангуулж, хувь хүний эрх, чөлөөг хамгаалж олон нийтийн аюулгүй байдал ба хэв журмыг сахиулахад гол үүрэг нь чиглэнэ. Эндээс харахад олон нийтийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэгж зайлшгүй байх шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийж байна.



Хууль сахиулахуй